

2026 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.10, 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох “Бороо Гоулд” ХХК-д энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан хөрөнгүүдийг тус хавсралтад заасан үнээр худалдан борлуулах, Банкны өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс хасахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д зөвшөөрсүгэй.
2. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 37 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох гүйлгээг хийх, шаардлагатай тохиолдолд энэхүү эрхээ шилжүүлэх итгэмжлэл олгох болон холбогдох бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОПША